



## Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: **МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**

Хөтөлбөрийн нэр: **СОЦИОЛОГИ**

Индекс: **D031402**

Шинжээчийн баг:

Ахлагч: Ш.Ариунаа (Sc.D), Профессор, ШУА-ны Бага чуулганы гишүүн

Гишүүд: С.Зулхар (Ph.D), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд

Б.Одгэрэл (Ph.D), Дэд профессор, ОТИС-ийн СЭШЭДЗахирал

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

## Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам гэх мэт
МУИС	Монгол улсын их сургууль

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр</b> /Монгол, Англи/	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр</b> /Монгол, Англи/	СОЦИОЛОГИ- SOCIOLOGY	
<b>Индекс</b>	D031402	
<b>Шинжээчид</b>	<p>Ахлагч: Ш.Ариунаа (Sc.D), Профессор, ШУА-ны Бага чуулганы гишүүн</p> <p>Гишүүд: С.Зулпхар (Ph.D), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Б.Одгэрэл (Ph.D), Дэд профессор, ОТИС-ийн СЭШЭДЗахирал</p>	
<b>Зохицуулагч</b>	Ц.Цацрал Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2022.03.07 А/59	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.
	2022.03.09 08/2022	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2022.03.19	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.03.24,25	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2022.05.02	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2022.05.06	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2022.05.09	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	Мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэр гарсан	

### II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-ийн ШУС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхим нь 1991 онд Социологийн

тэнхим нэртэйгээр байгуулагдаж социологич мэргэжлээр үндэсний боловсон хүчин бэлтгэж эхэлжээ. 1991 оноос хойш “Социологи” хөтөлбөрөөр сургалт явуулж байгаад 2000 онд “Нийгмийн ажил” хөтөлбөрийг нээж, тэнхимийн нэрийг 2006 онд албан ёсоор “Социологи, Нийгмийн ажлын тэнхим” болгож өргөтгөсөн. “Социологи” хөтөлбөр Монгол улсын хэмжээгээр социологийн анхны хөтөлбөр бөгөөд нээгдсэнээсээ хойш тасралтгүй гучин жилийн турш элсэлт авч байна. Хөтөлбөр нээсэн түүхээс дурдвал 1991 онд тухайн үед философийн ангид суралцаж байсан II, III курсийн оюутнуудаас сайн дурын үндсэн дээр сонголт хийлгэн социологийн ангид шилжүүлэн суралцуулж 1993 онд анхны төгсөлтөө хийжээ. 1993 оноос хойш нийтдээ 602 социологич мэргэжилтэн төгсгөөд байна. Дээд боловсролын салбарт 2014 онд хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр социологи хөтөлбөрт зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтийг оруулсан. “Социологи” мэргэжлийн хөтөлбөрийг D031402 индекстэйгээр батлуулахдаа дэлхийн шилдэг их сургуулиуд болох АНУ-ын Калифорнийн их сургууль, Бөрклэй (University of California, Berkeley 1 , USA), Колумбийн их сургууль (Columbia University 2 ), АНУ-ын Остин дахь Техасын их сургуулийн (The University of Texas at Austin 3 ) социологийн хөтөлбөрүүдтэй харьцуулж өнөөг хүртэл тогтвортой хэрэгжүүлж сургалтын үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Өдгөө тус салбар нь 16 багш, нэг туслах ажилтантай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар социологийн бакалаврын хөтөлбөрт нийтдээ 74 оюутан суралцаж байна.

**Зорилго:** Нийгмийн судалгааны гол хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тулгамдсан асуудлаар судалгаа, шинжилгээ, зөвлөх үйлчилгээг төлөвлөх, гүйцэтгэх, хөгжүүлэх, социологич-судлаачийн мэргэжлийн үндсэн үүргүүдэд хамаарах цогц чадамжуудыг эзэмшсэн, нийгмийн сайн сайхан байдал, хөгжил дэвшилд хувь нэмэр оруулж чадахуйц, хөрвөх чадвартай, ёс зүйтэй, мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

### **Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)**

МУИС-ийн СНАТ нь Социологи хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрийн шинэчлэлийг тогтмол хийсээр ирсэн. Хамгийн сүүлд 2014 онд дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд МУИС-ийн хийсэн бүтцийн өөрчлөлтөөр Социологи хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа дэлхийн шилдэг их сургуулиуд болох АНУ-ын Калифорнийн их сургууль, Бөрклэй, Колумбийн их сургууль, Остин дахь Техасын их сургуулийн социологийн хөтөлбөртэй харьцуулахын зэрэгцээ АНУ-ын социологийн холбооноос гаргасан 12 зөвлөмжийг мөрдлөг болгосон (Measuring college learning in Sociology, 2015). Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй сургалтын төлөвлөгөө нь МУИС-ийн захирлын 2014 оны А/259 тоот тушаалд заасан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт багтан батлагдсан. 2014 оны Социологи хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь нийт 120 багц цагийн агуулгатай ба дараах байдлаар задардаг. Үүнд, нэгдүгээрт МУИС-ийн төгсөгчийн судлах заавал судлах ерөнхий суурийн хичээлүүд 36 багц цаг; хоёрдугаарт нийгмийн ухааны салбар, бүрэлдэхүүн сургуулийн шаардлага, мөн социологийн хөтөлбөрийн шаардлагын дагуу заавал болон сонгон судлах 9 багц цаг, гуравдугаарт социологийн мэргэжлийн заавал судлах 45 багц цаг, дөрөвдүгээрт сонгон судлах 7 хичээл буюу 15 багц цагийн хичээлүүд тус тус багтсан. Социологи хөтөлбөрөөр суралцах оюутны хувьд ерөнхий суурийн 36 багц цагийн хичээл дотор /SOC1100/ Социологи, /SOC1101/ Нийгмийн судалгааны аргууд хичээлийг заавал судлах, сонгон судлах мэргэжлийн суурь хичээл, 9 багц цагийн суурь хичээлүүд дотор

/SOC1102/ Нийгмийн асуудлууд хичээлийг заавал судлах шаардлага тавьдаг. Суралцагч сургалтын төлөвлөгөөнд багтсан 120 багц цагаас 57 багц цагийн хичээлийг заавал судлах, 63 багц цагийн хичээлийн социологи хөтөлбөрийн төгсөгчдийн цогц чадамж болон өөрийн сонирхолд нийцүүлэн сонгон судлах боломжтой.

2014 оноос өмнө МУИС-ийн Социологи хөтөлбөр олон улсын социологийн холбооны социологич мэргэжлийн дээд боловсролын стандартыг дагаж мөрдөж байсан. Сүүлийн жилүүдэд үүсэн бий болж буй нийгмийн нөхцөл байдал, дээд боловсролын дэлхий нийтийн чиг хандлага социологи хөтөлбөрийг өргөн хүрээнд дахин боловсруулах шаардлагыг бий болгож байна. Хөтөлбөрийн багш нар, тэнхимийн зүгээс олон улсын социологийн холбооны зөвлөмж, шаардлагыг хөтөлбөртөө тусган ажиллах, Социологи хөтөлбөрийн цогц чадамжийг нийгмийн болон шинжлэх ухааны хөгжлийн шаардлагад нийцүүлэх талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ хүрээнд бид 2021 оны 4-р сараас эхлэн хөтөлбөрийн агуулга, төгсөгчдийн чадамж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ гэсэн агуулгаар төгсөгчид, ажил олгогчдын дунд онлайн хэлэлцүүлгийг цувралаар зохион байгуулж байна. МУИС-ийн Социологи хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, цогц чадамжийг тус хөтөлбөрийн багш нар боловсруулж, бакалаврын хөтөлбөрийг дүүргэсэн социологич нь социологич-судлаач, судлаач-дата аналит, мэргэжилтэн, манлайлагч чиглүүлэгч, багш гэсэн таван цогц чадамжтай байна гэж тодорхойлсон. Мөн МУИС-ийн төгсөгч нь иргэн хүнийхээ хувьд төрөлх хэлээ сайн эзэмшсэн байх, англи хэлийг ахисан түвшинд хэрэглэх, харилцааны өндөр ур чадвартай, бүтээлч байх, монголын түүх, соёл, хүний эрх зэрэг хүмүүнлэгийн мэдлэгээ практикт ашиглаж чаддаг байх, сэтгэлгээ, ёс суртахууны үнэлэмж төлөвшсөн байх, бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцсан, анхан шатны тусламж үзүүлж чаддаг байх, нийгмийн үүрэг хариуцлагаа ухамсарласан, мэргэжлийн ёс зүйн дүрмээ дагаж мөрддөг ёс зүйтэй мэргэжилтэн байх гэсэн ерөнхий чадамжуудыг эзэмшсэн байх шаардлагуудыг тусгасан. Дараах хүснэгтэд хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн загвар, цогц чадамжийг тодорхойлж, цогц чадамж бүрт чиглэсэн хичээлүүдийг харууллаа.

### Хүснэгт 3. Социологи хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн загвар, цогц чадамж

№	Хөтөлбөрийн зорилт	Төгсөгчийн загвар цогц чадамж	Сургалт (хичээл)
1	Социологийн онол арга зүйн суурь мэдлэгтэй болж, нийгмийн асуудлыг өнгөрсөн, одоо, ирээдүйн хүчин зүйлсийн нөлөөлөл, харилцан үйлчлэлийн хэлхээсэнд авч судлаж, дүн шинжилгээ хийдэг мэргэжилтэн бэлтгэх	<b>Социологич-судлаач</b> (researcher) гэсэн өргөн хүрээнд ажиллах ба социологийн үндсэн ойлголтоор асуудлыг таньж, тайлбарлаж чаддаг байх, бакалаврын эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх ур чадвартай байх	Сонгодог социологийн онол, Орчин үеийн социологийн онол, Нийгмийн давхраажил, Соёлын социологи, Гэр бүлийн социологи, Эдийн засгийн социологи, Бие хүн ба нийгэм
2	Нийгмийн судалгаа шинжилгээний онол арга зүй эзэмшүүлэх, Салбар дундын судалгааны арга зүй зарчмуудын суурийг эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэх	<b>Судлаач – дата аналит</b> , анхан ба хоёрдогч шатны төрөл бүрийн (дижитал) датаг бий болгож, эх сурвалжаас нь олж, боловсруулж ашиглаж, дүгнэж чаддаг байх	Чанарын судалгааны аргууд, Тоон судалгааны аргууд, Нийгмийн судалгааны мэдээлэл боловсруулах аргууд, Ахисан түвшний мэдээлэл боловсруулалт, Нийгмийн статистик
3	Нийгмийн суурь болон байгууллагын тулгамдсан асуудлаар бэсрэг төсөл хэрэгжүүлж, дүгнэлт санал зөвлөмж боловсруулдаг мэргэжилтэн бэлтгэх, Нийгмийн хариуцлагатай, идэвх санаачлагатай идэвхтэй иргэн бэлтгэх,	<b>Мэргэжилтэн</b> Хөтөлбөрийн хэрэглэгч байгууллагад тулгамдаад байгаа асуудлыг тодорхойлж, байгууллагын хэрэгцээнд нийцсэн бодлого, төсөл, хөтөлбөр, даалгаврыг тухайн гол талбарт /олон нийтийн харилцаа, орон нутгийн хөгжил, хүний нөөц гэх мэт/ санаачилж чаддаг байх	Мэдлэгийн социологи, Залуучуудын социологи, Боловсролын социологи, Түүхийн социологи, Шашны социологи, Хээрийн дадлага, Мэргэжлийн хичээлийн хүрээнд хийгддэг дадлага ажлууд
4	Орчин үеийн технологи, дижитал ололтын талаарх мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэх, Багаар болон бие даан ажиллах, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх чадвартай мэргэжилтэн бэлтгэх	<b>Манлайлагч, чиглүүлэгч</b> Тухайн микро ба байгууллагын бодлогын дотоод орчны холбогдогч талуудад нийгмийн тулгамдсан асуудлаар өөрчлөлтийг дэмжигч байх	Хүйс, жөндөр ба нийгэм, Улс төрийн социологи, Эрх зүйн социологи, Нийгмийн бодлого ба хамгаалал, Хэвлэл мэдээллийн социологи ба нийтийн соёл
5	Оюутны эрдэм шинжилгээний ажил бичдэг, амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх ур чадвартай, үр дүнгээ олон нийтэд илэрхийлэх, заан сургах чадвартай мэргэжилтэн бэлтгэх	<b>Багш</b> ЕБС, боловсрол сургалтын байгууллагад нийгэм, хувь хүний хөгжлийн чиглэлээр багшлах, сургалтын үйл ажиллагаа явуулах чадвартай байх	Мэдлэгийн социологи, Нийгэм судлал заах арга


Төгсөгчийн загвар - Цогц чадамж	Мэдлэг - Knowledge		Чадвар - Skills		Хандлага - Attitude	
Социологич - Судлаач	K1	69%	S1	69%	A1	55%
	K2	41%	S2	48%	A2	45%
Судлаач -Дата аналит	K3	59%	S3	55%	A3	55%
	K4	28%	S4	31%	A4	28%
	K5	21%	S5	31%	A5	34%
	K6	34%	S6	10%	A6	17%
Мэргэжилтэн	K7	48%	S7	55%	A7	38%
	K8	48%	S8	31%	A8	28%
	K9	21%	S9	24%	A9	10%
Манлайлагч, чиглүүлэгч	K10	45%	S10	45%	A10	21%
	K11	41%	S11	38%	A11	14%
Багш	K12	34%	S12	24%	A12	14%

## Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт

№	Хичээлийн төрөл	Лекц	Семинар	Дадлага	Бие даалт
1	Ерөнхий суурь	384	384		960
2	Мэргэжлийн суурь	96	96		140
3	Мэргэжлийн заавал судлах	512	320		
4	Мэргэжлийн сонгон судлах	416	64		400
5	Дадлага			544	
<b>Нийт</b>		<b>1408</b>	<b>864</b>	<b>544</b>	<b>1600</b>

## Сургалтын төлөвлөгөөний бүтэц

Захирлын 2014 оны А/259 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг

Хянасан:  Ч.Ундрэм, Сургалтын нэгдсэн албаны дарга

2015 он 8 сар 25 өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

### СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (Үндсэн мэргэжлийн)

Мэргэжил: Социологи  
Мэргэжлийн индекс: D031402  
Боловсролын зэрэг: Бакалавр

Суралцах хугацаа: 4 жил  
Нийт багц цаг: 120  
Элсэгчдийн боловсрол: Бүрэн дунд

Д.д.	Хичээлийн индекс	Хичээлийн нэр	Багц цаг	Улирал
<b>А. ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ</b>			<b>36</b>	
1	1	A1. Байгалийн ухааны чиглэл	6	I, II
2	2	A2. Нийгмийн ухааны чиглэл	6	I, II
3	3	A3. Хүмүүнлэгийн ухааны чиглэл	6	I, II
4	4	A4. Иргэний боловсролын чиглэл	3	I, II
5	5	A5. Судалгаа, шинжилгээний арга зүйн чиглэл	3	I, II
6	6	A6. Яриа, бичгийн ур чадварын чиглэл	3	I, II
7	7	A7. Англи хэл, бусад хэлний чиглэл	6	I, II
8	8	A8. Биеийн тамир, эрүүл ахуйн чиглэл	3	I, II

Тайлбар: Ерөнхий суурь хичээлийн чиглэл бүрээс хөтөлбөрийн шаардлагын дагуу хичээлүүдийг сонгон судалж нийт 36 багц цаг цуглуулна. (Хавсралт дахь хичээлүүдээс сонгох)

<b>Б. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ</b>			<b>9</b>	
<b>Б2. СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛ</b>			<b>9</b>	
9	1	STAT202 Эконометрикийн үндэс	3	III, IV
10	2	JOUR200 Сэтгүүл зүйн онолын үндэс	3	III, IV
11	3	POL1104 Дэлхийн улс төрийн бодлого	3	III, IV
12	4	POL1105 Ардчилсан засаглал ба иргэний нийгмийн оролцоо	3	III, IV
13	5	SOCI102 Нийгмийн асуудлууд	3	III, IV
14	6	ETNO100 Монголын угсаатны зүй	3	III, IV
15	7	ECON203 Дунд түвшний микроэкономикс	3	III, IV
16	8	ECON204 Дунд түвшний макроэкономикс	3	III, IV

Тайлбар: Нийгмийн ухааны суурь хичээлүүд байна. 9 Бү-ийн хичээл судлах шаардлагатай. SOCI102 Нийгмийн асуудлууд хичээлийг заавал судалсан байвал зохино.

<b>В. МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛ</b>			<b>60</b>	
<b>В1. ЗААВАЛ СУДЛАХ ХИЧЭЭЛ</b>			<b>45</b>	
17	1	SOCI200 Сонгодог социологийн онол*	3	III
18	2	SOCI201 Чанарын судалгааны аргууд*	3	III
19	3	SOCI202 Соёлын социологи	2	III
20	4	SOCI203 Нийгмийн давхраажил	3	III
21	5	SOCI204 Орчин үеийн социологийн онол	3	IV

22	6	SOCI205	Тоон судалгааны аргууд	3	IV
23	7	SOCI206	Нийгмийн судалгааны мэдээлэл боловсруулах аргууд	3	V
24	8	SOCI207	Гэр бүлийн социологи	3	IV
25	9	INTE200	Үйлдвэрлэлийн дадлага /танилцах/	1	IV
26	10	SOCI208	Эдийн засгийн социологи	3	V
27	11	SOCI209	Олон нийтийн санал бодлын социологи	2	V
28	12	SOCI210	Ахисан түвшний мэдээлэл боловсруулалт	3	VI
29	13	SOCI211	Хот хөдөөгийн социологи	2	VI
30	14	SOCI212	Эрх зүйн социологи	3	VI
31	15	SOCI213	Улс төрийн социологи	3	V
32	16	SOCI214	Боловсролын социологи	2	V
33	17	SOCI300	Шашны социологи	2	VI
34	18	FIEL300	Хээрийн дадлага	1	VI
<b>B2. Сонгон судлах хичээл</b>				<b>15</b>	
35	1	SOCI301	Хүйс, жендэр ба нийгэм	2	VI
36	2	STAT302	Нийгмийн статистик	2	VI
37	3	SOCI303	Түүхийн социологи	2	VII
38	4	SOCI304	Нийгэм судлал заах арга	2	VIII
39	5	SOCI305	Чөлөөт цаг ба амьдралын хэв маяг	2	VI
40	6	SOCI306	Залуучуудын социологи	2	VI
41	7	SOCI215	Хэвлэл Мэдээллийн Социологи ба Нийтийн Соёл	2	VII
42	8	SOCI216	Бие хүн ба нийгэм	2	VIII
43	9	SOCI217	Мэдлэгийн социологи	2	VII
44	10	SOCI218	Нийгмийн бодлого ба хамгаалал	3	VII
45	11	SOCI307	Хөдөлмөрийн социологи	2	VII
46	12	THES400	Бакалаврын судалгааны ажил	3	VIII

Тайлбар: B1 хэсгийн хичээлүүд нь залгамж холбоотой тул хичээлийн тодорхойлолтонд заасны дагуу дараалуулан судална.

<b>Чөлөөт сонголтын хичээл</b>				<b>15</b>	
--------------------------------	--	--	--	-----------	--

Тайлбар: МУИС-иас санал болгож байгаа нийт хичээлээс өөрийн хүсэл сонирхлоор сонгох бөгөөд сургалтын төлөвлөгөөний А, Б2, В2-ийн хичээлээс судалж болно. Чөлөөт сонголтын хичээлийг хавсрага болон хос мэргэжлээр суралцахад (шаардлага хангасан оюутан магистрын зэрэгцсэн хөтөлбөрт) тооцуулах боломжтой.

<b>Нийт багц цагийн дүн</b>				<b>120</b>	
-----------------------------	--	--	--	------------	--

**Төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага:**

1. Сургалтын төлөвлөгөөний дагуу 120-иос доошгүй багц цаг цуглуулна
2. Англи хэлний дундын дээд (Upper intermediate) түвшний шаардлага хангасан байна.
3. Нийт суралцсан хугацааны сурлагын голч дүн 1.8-аас дээш байна.

**Төгсөгчдөд тавих хөтөлбөрийн шаардлага:**

1. Социологич мэргэжлээр /major/ суралцах тохиолдолд оюутан МУИС-ийн Ерөнхий суурь хичээлээс I-III улиралд SOCI100 Социологи, SOCI101 Нийгмийн судалгааны аргууд хичээлүүдийг заавал сонгон судлах шаардлагатай.



### Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

*Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.*

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- Төгсөгч болон ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны сүүлийн таван жилийн харьцуулалт
- АНУ, Франц, Австрали улсын социологийн хөтөлбөрийн онцлогийг хэлэлцсэн “Социологийн хөтөлбөр дэлхий дахинд” вебинарын материал
- СНАТ-ийн цуврал хэлэлцүүлэг, түүний нотлох баримтууд
- БНХАУ-д хэрэгжиж байгаа социологи хөтөлбөрүүдийн харьцуулсан шинжилгээ
- АНУ-ын Социологийн холбооны Дээд боловсролын салбарын социологийн хөтөлбөр, хэрэгжилт, онлайн сургалтын тайланд хийсэн дүн шинжилгээ
- АНУ-ын Социологийн холбооны Ахлах сургуулийн социологи хөтөлбөрийн стандарт
- Их Британийн Социологийн холбоо “Хэрэглээний социологи” хөтөлбөр болон бусад судалгааны тайлан болон хөтөлбөрт хийсэн харьцуулсан шинжилгээ

##### Онцлог зүйл/Туршлага:

1. Нийгэм, ЭЗ, Технологи, салбарын хөгжлийн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн.
2. Олон улсын социологийн хөтөлбөрийн хөгжил хандлагыг тасралтгүй судлан, харьцуулж сайжруулах үйл ажиллагаа тогтмолжсон.
3. Оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлж мөшгөх болох сэтгэл ханамжийн судалгаа хийдэг.
4. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр нэгд, хичээлийн дадлагын хэсгийг үр дүнтэй болгох, дадлагын үр өгөөжийг сайжруулж дадлагын удирдамж, арга зүйг боловсронгуй болгож байсан. Харьцуулсан шинжилгээнд үндэслэн хөтөлбөрийг нэгд, хоёрдогч эх сурвалж дататай ажиллах, хоёрт социологичийн ёс зүйн асуудлын тусгаж “Нийгмийн судалгааны арга”, “Тоон”, “Чанарын” судалгааны хичээлүүдэд сайжруулалт хийсэн.
5. Судалгааны арга зүйн багц хичээл болон салбар социологийн агуулгыг багтаан цаг үеийн хэрэгцээ шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад төгсөгчдийн ур чадварыг нийцүүлэхээр хөтөлбөрийг боловсруулсан нь ярилцлага болон илрэл нотолгоогоор батлагдсан.

##### Анхаарах асуудал:

1. Төгсөгч болон ажил олгогчид, багш, суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг социологи хөтөлбөрт чиглүүлэн тогтмолжуулах

**Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

## 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### Илрэл нотолгоо:

- Социологийн хөтөлбөрийн мод-зураглал
- Батлагдсан сургалтын төлөвлөгөө 2014 оны А259 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг 2015 оны 8 сарын 25 өдрийн батлагдсан төлөвлөгөө
- МУИС-ийн бакалаврын хөтөлбөрийн зорилго, харьцуулалт
- Төгсөгчдийн болон оюутны сэтгэл ханамжийн судалгаа 2021
- Measuring college learning in sociology, 2015
- National standards for high school sociology
- Цогц чадамж болон хөтөлбөрийн зорилтуудын харьцуулалт
- МУИС хөтөлбөрийн хорооны журам
- Сургалтын төлөвлөгөөний дагуу боловсруулан батлуулсан хичээлийн хөтөлбөр
- Батлагдсан хичээлийн хөтөлбөрийн дагуу боловсруулсан хичээлийн багц Дадлага удирдан зохион байгуулахтай холбоотой баримт бичиг, гарын авлага

### Онцлог зүйл/Туршлага:

1. Байгууллагын эрхэм зорилго, хөтөлбөрийн эрхэм зорилго нийцтэй. Хөтөлбөрийн зорилтуудыг хөтөлбөрийн цогц чадамжтай холбож тогтоосон.
2. Хөтөлбөрийн зорилго зорилтуудыг тодорхойлохдоо байгууллагын эрхэм зорилго, байгууллагын стратегийн чиглэлтэй уялдуулсан.
3. Социологийн хөтөлбөрийн олон улсын стандарт, тэргүүлэгч улс орнуудын туршлагыг судлан хөтөлбөрт тусгасан.
4. Төгсөгчийн цогц чадамжийг 5 үндсэн чадамжтайгаар тодорхойлсон.
5. Суралцахуйн үр дүнг мэдлэг, чадвар, хандлагын түвшинд тодорхойлсон.

### Анхаарах асуудал:

1. Төгсөгчдтэй хамтын ажиллагаатай байгаа нь уулзалт, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, төсөл хөтөлбөрийн хэмжээнд идэвхтэй байгаа ч хөтөлбөрийн сайжруулалтын хүрээнд албажиж тогтмолжоогүй.

### Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн сайжруулалтад төгсөгчдийн санал, оролцоог нэмэгдүүлэх

**Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

## 1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### Илрэл нотолгоо:

- МУИС-ийн Сургалтын журам, холбогдох баримт бичиг

- Батлагдсан сургалтын төлөвлөгөө 2014 оны А259 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг 2015 оны 8 сарын 25 өдрийн батлагдсан төлөвлөгөө
- Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийн батлагдсан хөтөлбөрүүд
- Хичээлийн өөрчлөлтийг хэлэлцсэн, дэмжиж баталгаажуулсан хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- “Социологи” хээрийн дадлагын хөтөлбөр
- “Социологи, танилцах ба мэргэших дадлага”-ын хөтөлбөр
- МУИС-ийн сургалтын журам, МУИС-ийн суралцагчийн дадлагын журам
- “МУИС-ийн оюутны дадлагыг интерактив семинарын арга зүйн тусламжтайгаар хэрэгжүүлэх нь” гарын авлага УБ., 2018
- МУИС-ийн оюутны мэргэжих дадлага,интерншип-ын гарын авлага
- Дадлагын гуравласан гэрээ
- Дадлагын төлөвлөгөө
- Оюутны дадлагын дэвтэр
- Дадлагын интерактив семинарт бэлтгэх заавар
- “Социологийн хээрийн дадлага” чиглүүлэх сургалт

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан.
2. Хөтөлбөрийн үйл явцыг элсэлтээс төгсөлт хүртэл зохицуулсан дүрэм журамтай.
3. Суралцахуйн үр дүн, хичээл хоорондын уялдааны асуудлаар “Сургалтын хөтөлбөрийн мод” загвар боловсруулсан.
4. Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавартай.
5. Хичээл тус бүрийн хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. Батлагдсан хөтөлбөрийн дагуу боловсруулсан хичээл бүрийн багцтай.
6. Дадлагажигч оюутан нь хөдөлмөрийн харилцаанд оролцож, цаашдын ажил мэргэжлийн карьераа хэрэгжүүлэх ур чадварт суралцуулдаг. Дадлага хийхийн зэрэгцээ мэргэжилтний хувьд хөдөлмөрийн зах зээлд өөрийгөө таниулах, суралцаж байхдаа ажил орлоготой болох боломжтой
7. Ерөнхий суурь хичээл нь хөтөлбөрийн хувьд хөрвөх чадварыг сайжруулах, мөн мэргэшүүлэх гэсэн хоёр зорилт чадамжийг хангадаг. Хөтөлбөрийн зорилгыг ойлгож мэргэжил сонгоход ерөнхий суурийн хичээлүүд нь ихээхэн ач холбогдолтой. Үүнийг чухал хувь нэмэртэй гэж үздэг нь оюутнуудтай хийх ярилцлагын үед тодорсон. Хөрвөх чадварыг ерөнхий суурь хичээлээр олгож байгаа мэдлэг, чадвар, хандлага, ба чөлөөт сонголтын 15 кредит буюу 5-7 хичээлийг бусад тэнхим хөтөлбөрүүдээс сонгож хувь нэмэр оруулж байгаа нь илрэл нотолгоогоор баталгаажсан.
8. Мэргэжлийн хичээл бүр дээр тодорхой дадлагын багц цагийг тусгаснаар дадлага, талбарын ажлын туршлагыг нэмэгдүүлж байна.
9. Багш бүр хөтөлбөрийн онцлогоос хамаарч үнэлгээний ялгаатай арга барилыг ашигладаг. Шалгалт үнэлгээний хувьд оюутнуудад тохиромжтой бүтээлч шинж чанартай. МУИС-ийн сургалтын журмын 4.6 хэсгээр тухайн багшийн нэг хичээлийн үнэлгээний дундаж хазайлт, бодитой байдлыг тооцдог. Хичээл бүрийн хөтөлбөрт үнэлгээний журмыг хавсаргасан. Хичээл бүрээр өөр өөрийн үнэлгээний агуулгатай.

#### **Анхаарах асуудал:**

1. Дадлагын багц цагийг нэмэгдүүлэхэд анхаарч үндсэн дадлагын багцыг нэмэгдүүлэх саналыг оролцогч талуудаас гаргаж байна.

**Зөвлөмж:**

1. Дадлагын багц цагийг нэмэгдүүлэх
2. Багш бүр блүүм, рубрик үнэлгээний хүрээнд үнэлгээг сайжруулж байгааг үргэлжлүүлэх

**Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

*Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.*

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- Батлагдсан сургалтын төлөвлөгөө /2014 оны А259 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг 2015 оны 8 сарын 25 өдрийн батлагдсан төлөвлөгөө/
- МУИС-ийн бакалаврын хөтөлбөрийн зорилго, харьцуулалт
- Хөтөлбөрийн мод, цогц чадамж ба хичээл тус бүрээр уялдаж буй байдал
- Хичээл сонголт болон багш сонголт-СиСи систем
- Сургалтын цахим хэлбэрээр зохион байгуулж байсан Teams болон YouTube сувгуудад байрлуулсан багш нарын хичээл
- Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийн батлагдсан хөтөлбөрүүд
- Хичээлийн өөрчлөлтийг хэлэлцсэн, дэмжиж баталгаажуулсан хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Шалгалтын тестийн сан /Сиси болон бусад динамик системд байршсан/
- Бакалаврын орой, эчнээ хөтөлбөр оюутан элсүүлэх журам
- Бакалаврын түвшний оюутан мэргэжил солих журам
- Дадлага байгууллага сонгох удирдамж
- Бакалаврын түвшний оюутан мэргэжил солих журам
- МУИС-ийн цахим сургалтын түр журам
- МУИС-д гадаад оюутан элсүүлэх журам
- МУИС-ийн суралцагчдад тэтгэлэг олгох журам
- МУИС шилжүүлэн суралцуулах журам болон бусад холбогдох баримт бичиг

**Онцлог зүйл/Туршлага:**

1. Сургалтын агуулга нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй нийцсэн.
2. Дадлагын удирдамжийг шинэчлэн, дадлагын зохион байгуулах байгууллага болон тухайн байгууллагаас дадлага удирдагч нарыг сонгох бэлтгэх удирдамж,заавар, гэрээ, сургалтын багц боловсруулан хэрэгжүүлдэг.

3. Суралцагч хичээл багшийг сонгох боломжтой.
4. Мэргэжлийн болон мэргэшүүлэх багш нарыг сонгох боломж харьцангуй бага боловч бэлтгэгдсэн чадварлаг мэргэжлийн боловсон хүчин бүрдсэн.
5. Бусад салбар, тэнхим нэгжээс судлах хоёр бүлэг хичээлтэй.
6. Дадлага удирдах мэргэжилтнүүдэд зориулж хоёр жил тутам зохион байгуулдаг 4 багц цагийн сургалт зохион байгуулдаг
7. Оролцогч талуудаас гаргасан саналыг тусган дадлагын багц цагийг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа.
8. Судалгааны арга зүйн багц болон салбар социологийн агуулгыг багтаан цаг үеийн хэрэгцээ шаардлагад хөтөлбөрийг нийцүүлэн ажиллааж буй нь ярилцлага болон илрэл нотолгоогоор батлагдсан.

#### **Анхаарах асуудал:**

- Дадлага удирдах мэргэжилтнүүдэд зориулж хоёр жил тутам зохион сургалт цар тахлын үед зогсонги байдалтай байсан

#### **Зөвлөмж:**

- Дадлага удирдах мэргэжилтнүүдэд зориулж хоёр жил тутам зохион байгуулдаг 4 багц цагийн сургалт цар тахлын үед зогсонги байдалтай байсныг үргэлжлүүлж тогтмолжуулах

#### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн сургалтын журам
- Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийн батлагдсан хөтөлбөрүүд
- Хичээлийн өөрчлөлтийг хэлэлцсэн, дэмжиж баталгаажуулсан хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Хөтөлбөрт тусгагдсан заах арга зүй, үнэлгээний хэсэг
- МУИС-багшийн хөгжлийн хөтөлбөр
- Багшийг үнэлэх суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа СиСи системд
- МУИС-ийн цахим сургалтын түр журам
- Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар
- “Нийгэм судлал заах арга зүй” хичээлийн хөтөлбөр, багц
- “Багш ажилтны хөгжлийг дэмжих зардлын санхүүжилтийн журам”

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн сургалтын журамд хичээлийн арга зүйн ерөнхий хэлбэрийг тусгасан
- МУИС-ийн хичээлийн хөтөлбөр боловсруулах заавартай
- “Нийгэм судлал заах арга зүй” 2 багц цагийн хичээлтэй. Энэ чиглэлээрх мэргэшсэн багштай, БХЦСТ хамтран ажилладаг.

- Багш нарын хөгжлийн хэрэгцээ, тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг тандах зорилгоор хийгдсэн 2018, 2020 онуудын судалгаагаар илэрсэн багш нарын хэрэгцээ шаардлагад чиглэсэн хэд хэдэн сургалтыг Багшийн хөгжил, цахим сургалтын төвөөс жил бүр зохион байгуулдаг.
- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох дараах судалгааг Багшийн хөгжлийн төвөөс тогтмол хийдэг.
- Зарим хичээлийн хувьд шилдэг туршлага болохуйц боловсрогдож хөтөлбөрийн иж бүрэн багц бий болсон.
- Дадлагын явцыг нарийвчлан илүү үр дүнтэй болгоход чиглэсэн багц ажлыг хийсэн. Дадлагыг гэрээт байгууллагад, тусгайлан бэлтгэсэн мэргэжлийн удирдагчидтай хамтран удирдах сайн туршлага бий болсон.
- 2021 оны 01 сарын 20 ны А/13 тоот журмаар “Багш ажилтны хөгжлийг дэмжих зардлын санхүүжилтийн журам”-ыг шинээр баталсан. СНАТ-ийн хувьд багш нар тухайн санхүүжилтийг мэргэжлийн хөгжил, сургалт, арга зүй, эрдэм шинжилгээ судалгааны чадавхаа дээшлүүлэхэд зарцуулдаг.
- СНАТ-ийн зүгээс мөн шинэ залуу багш нарт сургалт, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлэх үүднээс дагалдуулан сургаж, хамтарч сургалтын үйл ажиллагааг явуулдаг. МУИС-ийн зүгээс залуу шинэ багш нарыг чиглүүлэх сургалтыг зохион байгуулж хэвшсэн.
- Номын сангийн хувьд шинээр ажилд орсон багш нарт зориулсан тусгай сургалттай.

#### **Анхаарах асуудал:**

1. Цогц чадамжид оруулж буй хувь нэмэр хичээлийн хөтөлбөрт тодорхой тусгагдаагүй байгааг анхаарах

#### **Зөвлөмж:**

1. Хичээлийн хөтөлбөр боловсруулахад цогц чадамж, хөтөлбөрийн зорилго агуулгыг уялдуулахад анхаарч хөтөлбөр боловсруулалтын арга зүйн сургалтуудыг зохион байгуулах

**Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн сургалтын журам
- Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийн батлагдсан хөтөлбөрүүд
- Хичээлийн өөрчлөлтийг хэлэлцсэн, дэмжиж баталгаажуулсан хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Хөтөлбөрт тусгагдсан заах арга зүй, үнэлгээний хэсэг
- МУИС-багшийн хөгжлийн хөтөлбөр
- Багшийг үнэлэх суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа СиСи системд
- МУИС-ийн цахим сургалтын түр журам
- Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар
- Сурлагын амжилт /2017-2021/

- Шалгалтын тестийн сан /Сиси болон бусад динамик системд байршсан/
- Төгсөлтийн ажил, дадлагын тайлан, бакалаврын судалгааны ажил

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Сургалтын үнэлгээний тухай МУИС-ийн сургалтын журамд заасан
2. Эзэмшвэл зохих мэдлэг чадварын түвшин 9 баллын системээр, хувьчилсан оноо, үсэг, тоон байдлаар үнэлдэг.
3. Тэнхимийн багш нар CDIO үнэлгээний аргачлалыг судлан өөрсдийн заадаг хичээл тус бүрийнхээ үнэлгээний рубрикийг боловсруулан хичээлийн эхэнд танилцуулдаг.
4. Блүүм таксаноми, Рубрик үнэлгээ хийх ажил үргэлжилж байгаа.
5. Шалгалтын хэлбэр, ялгаатай байдлыг судлан шинжилсэн. Хөтөлбөрт тусгасан.
6. Багшийн үнэлгээг шалгах, бодитой байх асуудлыг журмаар тусгаж өгсөн. Хөндлөнгийн үнэлгээ орж шалгах боломжтой
7. Тэнхимийн хөтөлбөрийн хороо болон бусад түвшинд хөтөлбөрийг үнэлэх, шаардлагатай бол 3 улирал дараалан сонгогдоогүй хичээлийг хаах хүртэл арга хэмжээ авдаг
8. Суралцагчдын амжилт, чанарыг СИСИ системээр дамжуулан улирал бүр, нэгж хичээл бүрд хийдэг. Уг асуулгын үр дүнд үндэслэн багшийн ажлыг дүгнэдэг. Багш өөрийн үнэлгээнд үндэслэн хичээлийн төлөвлөгөөнд сайжруулалт хийн, тэнхимийн хурлаар хэлэлцэн батлуулдаг.

#### **Зөвлөмж:**

1. Багш нар блүүмийн таксаноми болон рубрик аргаар хичээлийн үнэлгээг сайжруулж байгааг цаашид хичээл бүрд үргэлжлүүлэн сайжруулах, энэ чиглэлээр арга зүйн сургалтуудыг зохион байгуулах

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

*Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.*

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн сургалтын орчинтой холбоотой баримт
- МУИС-ийн номын сангийн шинэ байр 2017 онд ашиглалтад орсон. 700 гаруй суудалтай МУИС-ийн ШУС-ийн НУС-ын СНАТ-ын харъяа анги танхимуудад болон лекц, семинарын бүх танхимд алсын удирдлагатай проектор, дэлгэц, ухаалаг индэр, компьютер, интернет зэрэг мэдээллийн технологийн орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.
- Багш нарын өрөө нь шаардлагатай тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгслээр бүрэн хангагджээ.

- “Дата” төвийн тоног төхөөрөмжийн жагсаалт
- “Дата” төвийн үйл ажиллагаа
- “Дата” төвийн санхүүтэй холбоотой мэдээлэл

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. 2020 онд МУИС-ийн ШУС-иас хичээлийн 2-р байрны нийт 50 анги танхим 4 ариун цэврийн өрөөг бүрэн засварлаж, барилгын зүүн талын гадна фасадны хэсгийг засаж сайжруулсан. Нийт анги танхимын 40 хувьд засвар хийсэн ба байрны дулааны өгөх, буцах шугамыг бүрэн сольж, засварласан байна.
2. 2019 онд байгуулагдсан “Дата” төв нь 4 судалгааны ажлыг хэрэгжүүлж, 22 оюутанд 26.650.000 төг-ийн урамшуулал, 6 оюутанд 6.200.000 төг-ийн урамшуулал тус тус олгожээ.
3. Office 365 цахим шуудангийн үйлчилгээг Сиси мэдээллийн системтэй холбосон явдал бөгөөд оюутан бүрт автоматаар цахим шуудангийн хаяг үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.
4. Сүүлийн 5 жилд оюутнуудын орчноо үнэлсэн үнэлгээ нь социологийн хөтөлбөрийн заавал болон сонгон судлах хичээлийн хувьд дунджаар 2.5 байна.
5. Хичээлийн анги танхимыг хуваарийн дагуу үйлчилгээний ажилтнууд тодорхой цагуудад цэвэрлэдэг, агааржуулдаг, проектор техник хэрэгслийг жил бүр сайжруулж байна.
6. 2020-2021 оны намрын улиралд хичээлийг танхимаар орох болсноор оюутнууд орчноо 2.7 гэж үнэлсэн нь хамгийн өндөр оноо болсон төдийгүй КОВИД-19н хорио цээрээс улбаатай суралцахад цахим биш, танхимын орчныг дэмжиж буйн илэрхийлэл гэж дүгнэжээ .

### **Зөвлөмж:**

- Анги танхимын агааржуулалт, техникийн хангамжийн хүрэлцээг хангах, үе шаттайгаар сайжруулалт хийх төлөвлөгөө боловсруулан ажиллах

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш нарын хэвлүүлсэн судалгааны ажлын чиглэлийн дагуу нэгэн сэдэвт ном, сурах бичиг, гарын авлага, орчуулгын бүтээлүүд ба цахим мэдээллийн сангийн танилцуулгыг үзэж танилцав.
- “Багшийн хөгжил, цахим сургалтын төв” /БХЦСТ/-ийг шинээр байгуулсан байна.
- Багш нарын цахим хичээл бэлтгэх, зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулах журам батлан мөрдөж байна.



- МУИС-ийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны А/89 тоот тушаалаар баталсан “Цахим сургалтын түр журам”-д заасан хичээлийн багц материалыг багш нар боловсруулжээ.
- Социологи 60.5 кодтой ном сурах бичиг, СНАТ-ын ном, ВА&МА дипломын ажлын жагсаалт болон СНАТ-аас эрхлэн гаргадаг “Социологи, Нийгмийн Ажил” сэтгүүлүүдийг үзлээ.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. МУИС ийн КОХА системийн хайлтад Социологи, судалгаа хайлтаар: 2497 төрлийн материал 401 төрлийн ном сурах бичиг байна.
2. Социологи гэдгийг нь ялгахад 312 орос хэлээр, 60 орчим бүтээл англи хэлээр байрлуулсан байна.
3. Цахимд байрласан магистр, докторын ажлууд 102 ширхэг, гэрээр олгох хэсэгт давхардсан тоогоор 388 бүтээл байгаа нь социологиор сурч байгаа нийт 74 оюутнаас нэг хүнд 5 ном ногдож байна.
4. Номын төрлөөр нь харвал түүвэрлэлт статистик, боловсруулалтын SPSS аргатай холбоотой 4 төрлийн 80 ширхэг ном, судалгааны арга зүйтэй холбоотой 4 төрлийн 50 ном, социологи, социологийн онол түүхээр 3 төрлийн 94 ном байна.
5. Олон нийтийн санал бодол, эрх зүйн социологи, гэр бүлийн социологи зэрэг салбар социологийн хүрээнд ашиглагдах сурах бичиг гарын авлагууд байна.

#### **Зөвлөмж:**

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, болон бодит нөхцөлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах
- Цахим хичээлийн агуулгын төлөвлөгөө, стандарт боловсруулж ажиллах
- Дотоод сүлжээний системүүдийн хурдыг сайжруулах замаар цахим хичээл, сургалтын бусад үйл ажиллагааг дэмжихэд анхаарч системийн хөгжүүлэлтийг байнга хийх

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн номын сангийн шинэ байр нь 2017 онд ашиглалтад орсон цагаас чөлөөт сонголттой уншлагын танхим, гэрээр ном олгох фонд, нэг цэгийн үйлчилгээ, тогтмол хэвлэлийн уншлагын танхим зэрэг 15 цэг салбарт 700 гаруй суудлын багтаамжтайгаар үйлчилгээ үзүүлж байгааг үзэж танилцлаа.
- МУИС-ийн номын сан нь 2020-2021 оны хичээлийн жилийн байдлаар 390,000 гаруй хэвлэмэл болон цахим бүтээлийн сан хөмрөгтэй, олон

улсын онлайн мэдээллийн санг ашиглах боломжийг бүрдүүлэн уншигчдад үйлчилж байна.

- Оюутнууд цахим сүлжээнд бүрэн холбогдсон ба бүлгээр ажиллах өрөөг урьдчилан захиалж бие даан болон багаар ажиллах боломжийг бүрдүүлжээ.

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Багш нарын бичиж хэвлүүлсэн мэргэжлийн нэгэн сэдэвт бүтээлүүдийг Монголын нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын сургалт, судалгаанд өргөнөөр ашиглаж байна.
2. Номын сангийн сан хөмрөгийн нийт тоо 390 000, үүний 54% монгол, 36% орос, 10 % нь англи болон бусад хэл дээр хэвлэгдсэн ном, хэвлэлийн бүтээгдэхүүн байна. Уншигчдад чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд сургалтын агуулга, хөтөлбөрт нийцсэн ном, хэвлэлийн бүтээгдэхүүний бүрдүүлэлтийг хийж, холбогдох ангилал, данс бүртгэл, техник ажиллагааг хийж, каталогжуулан уншлага үйлчилгээнд гаргах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.
3. EBSCO мэдээллийн системээс Academic Search Premier, EBSCO eBook Collection (EBSCOhost) багц,
4. JSTOR онлайн мэдээллийн сан,
5. Research4Life -ийн AGORA, ARDI, HINARI, OARE, GOALI:
6. Springer Nature,
7. SAGE PUBLISHER,
8. Ecological Society of America,
9. Mathscinet,
10. The Geological Society of London,
11. Spie Digital Library,
12. PNAS,
13. Royal Society,

### **Зөвлөмж:**

- “Социологи” –хөтөлбөрөөр мэргэжлийн ном, сурах бичиг, шинээр хэвлэгдсэн бүтээлийн тоог нэмэгдүүлэх талаар үе шаттай арга хэмжээг төлөвлөн ажиллах

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

*Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.*

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж,

нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны түр журам МУИС-ийн захирлын 2014 оны 3-р сарын 3-ны өдрийн А/55 тушаалаар баталсан зурган файл <https://www.num.edu.mn/content.htm?mid=399>
2. МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны журам МУИС-ийн захирлын 2016 оны 12 сарын 23-ны өдрийн А/347 тоот тушаалаар баталсан
3. МУИС-ийн 2014 оны 4 сарын 17-ны өдрийн А/97 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар СНАТ-ийн хөтөлбөрийн хороо болон ахлагч, гишүүдийг баталсан. <https://www.num.edu.mn/Home/Content/3530> - хөтөлбөрийн хорооны бүтэц
4. 2015-2020 оны хөтөлбөрийн өөрчлөлтийн хурлын протоколууд
5. “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, БСШУСЯ-ны сайдын 2014.03.13-ны өдрийн А/78 тоот тушаал
6. “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, БСШУСЯ-ны сайдын 2014.04.28-ны өдрийн А/174 тоот тушаал

#### **Онцлог зүйл/Туршлага:**

Удирдлагын мэдээллийн системийг сургалтын үйл явцад бүхэлд нь нэвтрүүлсэн байна. Энэхүү системийг ашигласнаар сургах болон суралцах үйл явцад тулгамдаж байсан захиргааны зарим хүндрэлийг даван туулжээ.

#### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”, МУИС-ийн захирлын 2019.11.14-ний А/483 тоот тушаал.
- “МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам”.
- “МУИС-д технологийн коллеж төгсөгчийг суралцуулах түр журам”, МУИС-ийн захирлын 2019.08.27-ны өдрийн А/359 тоот тушаал.
- “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”, МУИС-ийн захирлын 2019.10.28-ны өдрийн А/462 тоот тушаал.
- “МУИС-ийн суралцагчийн дадлагын журам”, МУИС-ийн захирлын 2018.04.26-ны өдрийн А/136 тоот тушаал.
- “Сурган хүмүүжүүлэх дадлагын журам”, МУИС-ийн захирлын 2011.12.28-ны өдрийн 700 тоот тушаал.
- “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”, МУИС-ийн захирлын 2019.11.18-ны өдрийн захирлын А/495 тоот тушаал

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Багш, суралцагчдыг гадаадын ижил төстэй сургуульд мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулахад зохих түвшинд анхаарч иржээ.
2. 2014-2021 онд гадаад, дотоодын их сургууль, төр, төрийн бус байгууллагатай нийт 42 төсөл хамтран хэрэгжүүлсэн байна.
3. Төгсөгчидтэй хамтран ажиллах эргэх холбоо мэдээлэл харилцааны арга хэрэгсэлд суурилсан байдлаар идэвхжиж байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл татах системд хандах эрхийг нь авч ашиглах боломжтой байна.
4. Багш, суралцагч нар МУИС-ийн сүлжээнээс [https://library.num.edu.mn/?page\\_id=3987](https://library.num.edu.mn/?page_id=3987) сайтаар хандан гадаадын 16 онлайн мэдээллийн санг ашиглаж байгаа юм байна.
5. Хичээлийн жил бүр “Багш ажилтныг дэмжих сан”-аас санхүүжилт /жилд 5500000 төгрөг/ авч, тодорхой хувийг мэргэжлийн ном, сурах бичиг худалдан авахад зориулж иржээ.
6. “Социологи” хөтөлбөрийн IY курсын оюутнууд үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд тэнхимийн монгол болон орос, англи хэл дээрх мэргэжлийн сэтгүүлүүдийн контентыг цахимжуулан бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэн, сургалт, судалгаанд ашиглах боломжтой болгожээ.

#### **Анхаарах асуудал**

- Хөтөлбөрт ашиглах гадаад эх сурвалжийг нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

Хөтөлбөрийн аглуугыг шинэчлэхэд төгсөгчдийнхээ хөдөлмөр эрхлэх явцад олж авсан туршлага ур чадварыг үндэслэл болгох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талаарх тэдний төсөөлөл, таамаглалыг бүхий санал, зөвлөмжийг зохих түвшинд ашиглах.

#### **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “МУИС-ийн Сургалтын журам”, МУИС-ийн захирлын 2015.06.30-ны өдрийн А/203 тоот тушаал.
- “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”, МУИС-ийн захирлын 2019.11.14-ний А/483 тоот тушаал.
- “МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам”.
- “МУИС-д технологийн коллеж төгсөгчийг суралцуулах түр журам”, МУИС-ийн захирлын 2019.08.27-ны өдрийн А/359 тоот тушаал.
- “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”, МУИС-ийн захирлын 2019.10.28-ны өдрийн А/462 тоот тушаал.

- “МУИС-ийн суралцагчийн дадлагын журам”, МУИС-ийн захирлын 2018.04.26-ны өдрийн А/136 тоот тушаал.
- “Сурган хүмүүжүүлэх дадлагын журам”, МУИС-ийн захирлын 2011.12.28-ны өдрийн 700 тоот тушаал.
- “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”, МУИС-ийн захирлын 2019.11.18-ны өдрийн захирлын А/495 тоот тушаал
- МУИС-ийн стратеги төлөвлөгөө, тэнхимийн стратеги төлөвлөгөө – хэвлэсэн

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл татах системд хандах эрхийг нь авч ашиглах боломжтой байна.
2. Багш, суралцагч нар МУИС-ийн сүлжээнээс [https://library.num.edu.mn/?page\\_id=3987](https://library.num.edu.mn/?page_id=3987) сайтаар хандан гадаадын 16 онлайн мэдээллийн санг ашиглаж байгаа юм байна.
3. Хичээлийн жил бүр “Багш ажилтныг дэмжих сан”-аас санхүүжилт /жилд 5500000 төгрөг/ авч, тодорхой хувийг мэргэжлийн ном, сурах бичиг худалдан авахад зориулж иржээ.

### **Анхаарах асуудал:**

Орлогын 60 хувиас хэтрүүлэлгүй хөтөлбөрт зарцуулах зохицуулалттай ажээ. Төсөв санхүүгийн хувьд төрийн өмчит сургуулийн жишгээр нэгдмэл удирдлагатай учир бүрэн бие даасан санхүүгийн удирдлага хэрэгжүүлэх боломжгүй гэж ойлголоо. Үүнийг төсөв санхүүгийн хувьд хөтөлбөрт бий болж болох эрсдлийг багагсгах зохицуулалт гэж ойлгож болох ч нөгөө талаар сургалт, судалгааны чадавхыг бэхжүүлэх хөрөнгө санхүүгийн зохистой боломжийг ашиглах нөхцлийг хязгаарлах талтай байж болох юм.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрөөр ашиглах гадаад эх сурвалжийг нэмэгдүүлэх

### **Шаардлага:**

Хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, эсхүл зохистой механизмыг нээж өгөх.

### **Шалгуурыг хангасан байдал: хэсэгчлэн хангасан**

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- “OPEN MIND MONGOLIA” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг “Supporting Social Well-being during and after COVID 19” сэдвээр зохион байгуулсан мэдээлэл

- Эрэл шийдэл хурлын мэдээлэл  
<https://www.facebook.com/groups/852887034749876/search/?q=%D1%8D%D1%80%D1%8D%D0%BB%20%D1%88%D0%B8%D0%B9%D0%B4%D1%8D%D0%BB>
- Фэйсбүүк группуудын линк - [СОЦ-НА ОЮУТАН | Facebook](#)
- Багш, оюутны намрын спорт тэмцээний мэдээлэл  
<https://www.facebook.com/groups/852887034749876/media>
- Төгсөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.
- Ажил олгогчидтой хийсэн уулзалтын тэмдэглэл.

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судалж тэдний 76.5 хувь ажил хөдөлмөр эрхэлж байгааг тогтоожээ. Нөгөө талаар хөдөлмөрийн зах зээлд тухайн мэргэжлээр суралцуулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлох судалгаа, уулзалт, тандалт хийсэн байна.
2. Төгсөгчид болон ажил олгогчидтой хийсэн уулзалтын явцад тэд хөдөлмөрийн зах зээлд өргөн сонголттой ажиллах бүрэн боломжтой мэргэжил болохыг нотолж байв. Түүнчлэн тус мэргэжлээр суралцагчдын хөрвөх чадвар нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн аль ч байгууллагад ажиллах боломж өргөжүүлэх хандлага ажиглагдаж байв.
3. Зарим төгсөгчид болон төгсөх курсын оюутнууд тус хөтөлбөрт элсэн суралцахдаа тэр бүр бүрэн мэдээлэлтэй байж чадаагүйгээ тэмдэглэж байв. Харин суралцагчид 1 дүгээр курсээс эхлэн мэргэжил сонгох болсоноор социологи мэргэжлийн талаар тэнхим, багш нартай уулзаж маш тодорхой мэдээлэл авах болжээ.

### **Зөвлөмж:**

